ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/19/СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг Сайншанд сум)
2019 он


Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг: ..............................
Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 90077079 Цахим хаяг: ..............................
Аудитор: Э.Батчимэг
Утас: 99032916 Цахим хаяг: ..............................


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймаг , Төрийн аудитын газар , Сайншанд сум , Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ 3
2 Аудитын тайлан 5
2.1 Оршил....5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага....5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт....6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин....6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ....7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал....7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар....8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..9
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал....9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга....9
2.11. Шилэн дансны мэдээлэл....10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга....10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл....10
3 Менежментийн захидал 11
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан 13

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34

2019.02.26 № 1-6/218

танай ______ -ны № ______ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Н.БАТМӨНХ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаардлаг.

Аудитаар Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Н.Батмөнх-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 17-наас 2019 оны 2 дугаар сарын 18–ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг нь “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж өөрийн тойргийн харьяалалын хүүхдийн хамрагдалтыг тодорхой түвшинд нэмэгдүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насныханд анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчин томоохон шинэчлэлт өөрчлөлт гаргаагүй байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд (нийцсэн) байна.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэргэжилтэн шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous санхүүгийн програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын хүүхдийн Цэцэрлэг дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (Бага) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт ( Үр нөлөөгүй) гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардал-ын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Батлагдсан төсвөөс зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны Нийт зардал 222,432.1 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 444.89 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг *0.2* хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 3 | 46,859.80 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 3 | 46,859.80 | |

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХХОАТ-ын тооцооноос 2134212,5 төгрөг илүү шилжүүлж авлагын үлдэгдэлтэй гарсан байна

Энэ нь бодитой оршин байх ба тохиолдсон байх , эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 196,835.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 196,420.4 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалингийн зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр тайлагнасан байна
2. Хууль тогтоомжийн дагуу ХЧТА-н тэтгэмж авч байгаа ажилчдад тэтгэмжийг олгохдоо ХХОАТ гэж 10%-г суутган дутуу олгосон байна. Тухайлбал 2018.02.02-нд Л.Эрдэнэсувдад 4280 төгрөг , Т.Наранцэцэгт 18271 төгрөг , 2018.04.25-нд Б.Насанжаргалд 4039 төгрөг тус тус дутуу олгосон байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

**3.1 Балансын данстай холбоотой асуудал**

3.1.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр тайлагнасан байна

Энэ нь үнэн зөв байх , иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар , НБББББичгийг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

бараа материалын тайланг нэр төрлөөр гаргадаггүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар , Боловсрол , соёл , шинжлэх ухаан , спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах , бараа материалд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

**3.2 Зардлын данстай холбоотой асуудал**

3.2.1 Илрүүлэлт:

Хууль тогтоомжийн дагуу ХЧТА-н тэтгэмж авч байгаа ажилчдад тэтгэмжийг олгохдоо ХХОАТ гэж 10%-г суутган дутуу олгосон байна. Тухайлбал 2018.02.02-нд Л.Эрдэнэсувдад 4280 төгрөг , Т.Наранцэцэгт 18271 төгрөг , 2018.04.25-нд Б.Насанжаргалд 4039 төгрөг тус тус дутуу олгосон байна

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ХХОАТ-ын тухай хууль , Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль дүрэм журам зөрчигдсөн байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.1 " хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр , тэтгэмж , төлбөр , үзүүлж байгаа хөнгөлөлт , нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж"-ийг албан татвараас чөлөөлнө гэж заасан бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр , тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дах заалтын 1 дэх хэсэгт "хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж"-ийг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөлд хамаарна" гэж заасан байна. Иймд ХЧТА-н тэтгэмж нь хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэмж тул ХХОАТ-н тухай хуулийн 16.1.1-д заасны дагуу албан татвараас чөлөөлөгдөнө.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

СТ-1А

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 40,010,102.44 | 46,833,172.74 |
| 33 | **АВЛАГА** | 10,011,837.50 | 2,134,212.50 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 459,000.00 | |
| 335 | **Бусад авлага** | 9,552,837.50 | 2,134,212.50 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 9,552,837.50 | 2,134,212.50 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 29,998,264.94 | 44,698,960.24 |
| 351 | **Түүхий эд материал** | 4,000.00 | 4,000.00 |
| 35130 | Эм боох материал | 4,000.00 | 4,000.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 29,994,264.94 | 44,694,960.24 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 473,460.00 | 288,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,634,116.50 | 24,433,511.80 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 312,000.00 | 2,058,750.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,200,440.00 | 2,176,750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,374,248.44 | 15,737,948.44 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 623,424,547.63 | 1,486,027,992.10 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 623,424,547.63 | 1,486,027,992.10 |
| 392 | **Биет хөрөнгө** | 623,424,547.63 | 1,478,317,992.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 679,435,906.77 | 1,417,556,782.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (89,193,578.76) | |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 42,334,742.27 | 60,402,070.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (29,581,835.03) | (32,313,988.01) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,701,526.98 | 56,624,456.25 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (21,842,592.17) | (26,289,096.06) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,306,070.00 | 6,306,070.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,863,825.18) | (6,096,435.80) |
| 39217 | Ном | 2,128,132.75 | 2,128,132.75 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | | 7,710,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 7,710,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 663,434,650.07 | 1,532,861,164.84 |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 66,779.00 | |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 66,779.00 | |
| 413 | **Өглөг** | 66,779.00 | |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 66,779.00 | |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 663,367,871.07 | 1,532,861,164.84 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 663,367,871.07 | 1,532,861,164.84 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 750,592,070.82 | 758,302,070.82 |
| 51101 | Өмч: - төрийн | 750,592,070.82 | 758,302,070.82 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | (87,623,682.30) | 756,962,555.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (87,623,682.30) | (87,623,682.30) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 844,586,237.62 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 399,482.55 | 17,596,538.70 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 663,434,650.07 | 1,532,861,164.84 |

4417144353
ЕЮА0056 9025707

СТ-2А

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **113,993,255.00** | **1,066,171,458.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,130,055.00** | **869,335,758.05** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,130,055.00 | 869,335,758.05 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,130,055.00 | 869,335,758.05 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,130,055.00 | 869,335,758.05 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **112,863,200.00** | **196,835,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 112,863,200.00 | 196,835,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 112,863,200.00 | 196,835,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **99,940,744.04** | **222,432,142.59** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **99,940,744.04** | **222,432,142.59** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 96,448,944.04 | 216,505,495.59 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 63,095,258.00 | 135,788,190.00 |
| 210101 | Үндсэн цалин | 54,850,869.00 | 117,506,122.00 |
| 210102 | Нэмэгдэл | 3,719,100.00 | 5,568,900.00 |
| 210104 | Урамшуулал | 2,964,189.00 | 9,830,268.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,561,100.00 | 2,882,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,922,612.00 | 15,626,621.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,476,890.00 | 10,812,044.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 611,430.00 | 1,622,469.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 489,144.00 | 547,874.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 122,288.00 | 240,392.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,222,860.00 | 2,403,842.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,728,734.50 | 10,145,858.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,145,857.00 | 4,620,537.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,495,377.50 | 5,312,475.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 87,500.00 | 212,846.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 585,854.00 | 6,176,444.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 212,750.00 | 1,280,981.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 41,000.00 | 939,859.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 55,000.00 | 275,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 277,104.00 | 3,680,604.70 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,476,738.00 | 28,081,140.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 40,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,476,738.00 | 28,041,140.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 140,200.00 |
| 210604 | Урсгал засвар | | 140,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 47,400.00 | 298,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 47,400.00 | 298,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 264,200.00 | 491,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 264,200.00 | 491,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,328,147.54 | 19,757,641.89 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 22,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,328,147.54 | 19,735,641.89 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,491,800.00 | 5,926,647.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,491,800.00 | 5,497,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,466,800.00 | 5,497,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 25,000.00 | |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 428,847.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 428,847.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **14,052,510.96** | **843,739,315.46** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | 860,982.73 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | | 860,982.73 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,134,032.00 | (14,060.57) |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,134,032.00 | (14,060.57) |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (1,134,032.00) | 846,922.16 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **12,918,478.96** | **844,586,237.62** |

СТ-3А

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 180,073,400.00 | 196,849,200.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 13,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 13,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 13,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 13,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 180,073,400.00 | 196,835,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 178,073,400.00 | 196,835,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 178,073,400.00 | 196,835,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,000,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 170,007,440.00 | 190,501,400.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 170,007,440.00 | 190,501,400.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 156,923,280.00 | 184,574,753.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 105,832,702.00 | 127,924,065.00 |
| 210101 | Үндсэн цалин | 88,272,950.00 | 110,162,230.00 |
| 210102 | Нэмэгдэл | 5,568,900.00 | 5,568,900.00 |
| 210104 | Урамшуулал | 9,107,952.00 | 9,310,035.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,882,900.00 | 2,882,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 13,255,300.00 | 15,693,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,517,565.00 | 10,975,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,176,344.00 | 1,179,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 949,704.00 | 943,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 237,428.00 | 235,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,374,259.00 | 2,359,100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,923,969.00 | 8,726,858.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,651,469.00 | 4,620,537.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 3,893,475.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 272,500.00 | 212,846.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,856,346.00 | 1,951,580.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 68,500.00 | 169,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 940,000.00 | 939,859.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 192,606.00 | 364,921.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 51,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,655,240.00 | 426,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 26,154,913.00 | 28,221,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 55,500.00 | 40,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,899,413.00 | 28,017,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,200,000.00 | 163,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 141,000.00 | 292,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 152,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 141,000.00 | 140,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 277,800.00 | 283,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 277,800.00 | 283,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 651,900.00 | 651,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 651,900.00 | 651,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 829,350.00 | 830,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 829,350.00 | 830,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,084,160.00 | 5,926,647.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,713,000.00 | 5,497,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,512,000.00 | 5,497,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,201,000.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 371,160.00 | 428,847.00 |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 371,160.00 | 428,847.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 10,065,960.00 | 6,347,800.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 10,065,960.00 | 6,347,800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 10,065,960.00 | 6,347,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 10,065,960.00 | 6,347,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал | 10,065,960.00 | 6,347,800.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (10,065,960.00) | (6,347,800.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | | |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

СТ-4А

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | | | |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | | |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | |
| C08 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | | | |
| D01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **750,592,070.82** | **399,482.55** | **(87,623,682.30)** | | 663,367,871.07 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **750,592,070.82** | **399,482.55** | **(87,623,682.30)** | | 663,367,871.07 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 17,197,056.15 | | | 17,197,056.15 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 7,710,000.00 | | 844,586,237.62 | | 852,296,237.62 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **758,302,070.82** | **17,596,538.70** | **756,962,555.32** | | **1,532,861,164.84** |

ТГ

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 196,835,700.00 | 196,420,353.00 | 415,347.00 | 99.8% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 196,835,700.00 | 196,420,353.00 | 415,347.00 | 99.8% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 191,337,900.00 | 190,922,553.00 | 415,347.00 | 99.8% |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 128,311,700.00 | 127,924,065.00 | 387,635.00 | 99.7% |
| 210101 | Үндсэн цалин | 110,526,900.00 | 110,162,230.00 | 364,670.00 | 99.7% |
| 210102 | Нэмэгдэл | 5,568,900.00 | 5,568,900.00 | | 100.0% |
| 210104 | Урамшуулал | 9,333,000.00 | 9,310,035.00 | 22,965.00 | 99.8% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,882,900.00 | 2,882,900.00 | | 100.0% |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 15,693,400.00 | 15,693,400.00 | | 100.0% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,975,200.00 | 10,975,200.00 | | 100.0% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,179,600.00 | 1,179,600.00 | | 100.0% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 943,600.00 | 943,600.00 | | 100.0% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 235,900.00 | 235,900.00 | | 100.0% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,359,100.00 | 2,359,100.00 | | 100.0% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,750,300.00 | 8,726,858.00 | 23,442.00 | 99.7% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,624,200.00 | 4,620,537.00 | 3,663.00 | 99.9% |
| 210302 | Түлш, халаалт | 3,894,400.00 | 3,893,475.00 | 925.00 | 100.0% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 231,700.00 | 212,846.00 | 18,854.00 | 91.9% |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,954,400.00 | 1,951,580.00 | 2,820.00 | 99.9% |
| 210401 | Бичиг хэрэг | 170,000.00 | 169,300.00 | 700.00 | 99.6% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 940,000.00 | 939,859.00 | 141.00 | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 366,000.00 | 364,921.00 | 1,079.00 | 99.7% |
| 210404 | Ном, хэвлэл | 51,000.00 | 51,000.00 | | 100.0% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 427,400.00 | 426,500.00 | 900.00 | 99.8% |
| 2105 | Нормативт зардал | 28,221,900.00 | 28,221,250.00 | 650.00 | 100.0% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 40,000.00 | 40,000.00 | | 100.0% |
| 210502 | Хоол, хүнс | 28,018,100.00 | 28,017,450.00 | 650.00 | 100.0% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 163,800.00 | 163,800.00 | | 100.0% |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,641,000.00 | 6,640,200.00 | 800.00 | 100.0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,500,000.00 | 5,500,000.00 | | 100.0% |
| 210602 | Тавилга | 1,000,000.00 | 1,000,000.00 | | 100.0% |
| 210604 | Урсгал засвар | 141,000.00 | 140,200.00 | 800.00 | 99.4% |
| 2107 | Томилолт, зочны зардал | 283,300.00 | 283,300.00 | | 100.0% |
| 210702 | Дотоод албан томилолт | 283,300.00 | 283,300.00 | | 100.0% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 651,900.00 | 651,900.00 | | 100.0% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 651,900.00 | 651,900.00 | | 100.0% |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 830,000.00 | 830,000.00 | | 100.0% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 830,000.00 | 830,000.00 | | 100.0% |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,497,800.00 | 5,497,800.00 | | 100.0% |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | | | | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | | | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,497,800.00 | 5,497,800.00 | | 100.0% |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,497,800.00 | 5,497,800.00 | | 100.0% |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 196,835,700.00 | 196,849,200.00 | (13,500.00) | 100.0% |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 196,835,700.00 | 196,835,700.00 | | 100.0% |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 196,835,700.00 | 196,835,700.00 | | 100.0% |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | 13,500.00 | (13,500.00) | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 13,500.00 | (13,500.00) | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | | | | |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 17 | 17 | | 100.0% |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8 | 8 | | 100.0% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | | 100.0% |
| 620004 | Гэрээт ажилтан | | | | |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | | | | |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | | | | |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | | | | |
| 632 | МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ | | | | |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | | | | |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | | | | |